

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.84-д Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тусгагдсан юм.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дараах ажлууд туссан билээ.

- **2.81.12-д** Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах;
- **2.80.7-д** Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах;
- **2.81.13-д** Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх;
- **5.2.4-д** “Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ”, 2 дугаар хэсэгт Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох;
- **5.2.4-д** “Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ”, 3 дугаар хэсэгт Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүлэх;
- **2.80.5-д** “Орон зайн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулна.”;
- **2.81.9-д** “Төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох”;
- **2.81.10-д** “Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх.”;
- **2.81.11-д** “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх.”
- **2.81.12-д** “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах”;
- **5.1.17.1-д** “Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлууд тус тус төлөвлөгдсөн юм.

Иймд дээрх төлөвлөгөөний дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн 5 систем, 3 төрлийн мэдээллийн санг нэвтрүүлээд байна. Үүнд:

1. Геодези, зураг зүйн мэдээллийн сан
2. Геологи, хүрээлэн буй орчны мэдээллийн сан
3. Хаягийн мэдээллийн сан
4. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем
5. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэдээллийн систем
6. Газрын биржийн цахим систем
7. Газрын үнэлгээний систем
8. Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг тус тус нэвтрүүлэв.

---oOo---

1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЦАХИМ СИСТЕМ

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаарх мэдээллийг онлайнгаар хүлээн авч, саналаа өгөх боломжтой боллоо.

Улсын хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлээ. Энэхүү мэдээллийн систем нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, оролцоонд түшиглэсэн болгож байгаагаараа онцлог юм.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем байгуулагдсанаар дараах боломжууд бүрдэж байна. Үүнд:

1. Улс, аймаг, нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нийлсэн 766 төлөвлөгөө бүхий мэдээллийн сан бүрдээд байна. Уг мэдээллийн санд орсон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийг иргэд, олон нийт, төрийн байгууллагууд цахимаар нээлттэй авах боломжтой бүрдсэн.
2. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээр дамжуулан иргэд, олон нийт болон салбарын төрийн байгууллагууд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд саналаа өгч тусгуулах, иргэн, хуулийн этгээд газар эзэмших, ашиглах, өмчлөх газрын байршлаа сонгож, хүсэлт гаргах боломжтой.
3. Иргэд, олон нийт газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих бүхий үе шатанд нээлттэй оролцож, хяналт тавих боломжтой. Ингэснээр холбогдох газар олгох үйл явц нээлттэй болж, хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд олон нийт тавих боломж бүрдсэн.
4. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээр дамжуулан салбар бүрийн төрийн байгууллагууд болон газрын мэргэжлийн төрийн бус байгууллагууд хамтран орон зайн хувьд давхардалгүй, харилцан уялдаатай байршилд суурилсан орон зайн төлөвлөлтөө хоорондоо харилцан уялдаатайгаар нэгдсэн байдлаар төлөвлөх боломж бүрдсэн.

Энэхүү систем нэвтэрснээр газрын харилцааны бүхий л асуудал зөвхөн газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжин хэрэгжих нөхцөлийг бий болгох бөгөөд улмаар газрыг төлөвлөлтгүй, эмх замбараагүй олгож, газрын зөрчил, маргаан үүсгэж иргэдийн эрх ашгийг хохироох аливаа асуудалд цэг тавьхаас гадна, салбарууд хоорондын уялдаагүй байдлаас үүдсэн давхардсан төлөвлөлт, үргүй зардлыг бууруулж, газарт оруулж буй хөрөнгө оруулалтыг илүү эрсдэлгүй, баталгаатай болгож байгаа юм.

---oOo---

2. ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ҮНДЭСНИЙ МОНИТОРИНГИЙН СҮЛЖЭЭГ БАЙГУУЛАВ

Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хамтран Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээ, мэдээллийн нэгдсэн системийг байгуулан ажиллаа.

Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үндэсний сүлжээ нь нийт нутаг дэвсгэрийг хамарсан ажиглалтын талбар, мониторингийн 15'000 орчим цэгийн мэдээллээр дамжуулан газрын харилцааны салбарын оролцогч талуудыг нэгдсэн арга зүйгээр хангах, харилцан мэдээлэл солилцох, газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг эрт үед нь илрүүлэх, үнэлэх, доройтлоос урьдчилан сэргийлэх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх зэрэг цогцолбор үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Мөн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний сүлжээ байгуулах ажлын хүрээнд төрийн өмчийн болоод иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтөд үзүүлэх хүний болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөллийг богино хугацааны давтамжтай тодорхойлж, түүнд тохирсон газар зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой авч хэрэгжүүлэх, бусад газрын харилцааны цахим системүүдтэй уялдаж ажиллах цахим системийг байгууллаа.

Энэхүү цахим систем нэвтэрснээр дараах асуудлуудыг шийдвэрлэлээ. Үүнд:

1. Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 /Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана/-д заасны дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт төлөв байдал, чанарын хяналтыг бүрэн тавих;
2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газартаа газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргах шат, дамжлагыг багасган, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, ил тод, нээлттэй явуулах;
3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газар хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, нэгдсэн арга зүйн, нэгдсэн мэдээллийн санг байгуулан иргэд, олон нийт болоод шийдвэр гаргагч нарыг нэгдсэн мэдээллээр хангах боломж нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

---oOo---

2.1. ГЕОЛОГИ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГ НЭВТРҮҮЛЭВ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 2013 оноос тус байгууллагын хэмжээнд өмнөх онуудад судалгаа, шинжилгээний ажлуудын хүрээнд бий болсон геологи, хүрээлэн буй орчны цаасан болон аналог мэдээллүүдийг тоон хэлбэрт нэгдсэн стандартын дагуу шилжүүлж тоон мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн билээ.

Тухайн мэдээллийн санд Газар чичирхийлэл-газар хөдлөл, геологи, тектоник-шинэ тектоник, геоморфологи, ашигт малтмал, гидрогеологи, гидрологи, инженер-геологи, түүх-археологи, хөрс, ургамал, уур амьсгал зэрэг үндсэн 10 давхаргын 73 дэд мэдээллийн санг бүрдүүлээд байна.

Геологи, хүрээлэн буй орчны мэдээллийн санд улсын хэмжээний жижиг масштабын зургууд болон сум суурин газрын том масштабын инженер геологийн сэдэвчилсэн зургуудаас бүрдэх бөгөөд 1975-2000 онд хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд үүссэн төрөл бүрийн аналог буюу цаасан зургуудыг тоон системд хөрвүүлсэн бол 2013-2017 онд Улаанбаатар хот болон 12 аймгийн төвийн газар хөдлөлийн бичил мужлалын зургийг шинээр боловсруулаад байна.

Газар хөдлөлийн бичил мужлалын зураг, инженер-геологи, гидрогеологи геологи нь хот, суурин газрын нутаг дэвсгэрт барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл болох төдийгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, ард иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдруулах боломжийг бүрдүүлж байгаа нь өндөр ач холбогдолтой юм.

Мөн дээрх мэдээллийг байгууллагын геопортал-аар дамжуулан иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудад нээлттэй гаргаж, геологи, хүрээлэн буй орчны баталгаатай мэдээллийг нэг эх үүсвэрээс авах боломжийг бүрдүүлэн ажиллаа.

---oOo---

2.2. БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ФОТО МОНИТОРИНГИЙН АРГААР ҮНЭЛЭХ АЖИЛ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 2015 оноос эхлэн Швейцарын хөгжлийн агентлаг Ногоон-Алт төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлэн 5 дахь жилдээ ажиллаж байна.

Энэхүү ажил нь бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, хамгаалах, түүний хэрэгжилтэд хяналт тавихад суурь мэдээлэл болж байна.

Бэлчээрийн төлөв байдал: 2019 онд улсын хэмжээнд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 314 сумын 109'266'437 га талбайг төлөөлүүлэн 4781 мониторингийн цэгт зохион байгуулан хийсэн байна.

2019 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 16'980'938 га талбай байгалийн унаган төрхөө алдаагүй, 40'470'023 га талбай бага зэрэг доройтсон, 21'100'166 га талбай дунд зэрэг доройтсон, 24'127'776 га талбай хүчтэй доройтсон, 4'694'822 га талбай маш хүчтэй доройтсон дүн гарсан байна.

---oOo---

3. ГАЗРЫН БИРЖИЙН ЦАХИМ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭВ /www.mle.mn/

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн.

Газрын биржийн цахим системийг нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрээд байна. Үүнд:

- Газраас олох эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлсэн;
- Газрын дуудлага, худалдаа, төсөл сонгон шалгаруулалт улсын хэмжээнд ил тод зохион байгуулагдаж нэгдсэн зохион байгуулалтанд орсон;
- Газрын худалдаа, арилжааны нэгдсэн мэдээллийн сантай болж, хяналтын тогтолцоо сайжрах нөхцөл бүрдсэн;
- Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн сан байгуулж зах зээлийн үнэ ханш, эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлтийг жигд тогтвортой байлгаж эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлсэн;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт /Засгийн газрын XII байр болон Нийслэлийн иргэдэд үйлчлэх нэгдсэн төв Дүнжингарав дахь салбарт “Газрын биржийн цахим төв”-үүдийг байгуулж, иргэд олон нийтэд үйлчилгээг үзүүлэх болсон

Тухайлбал 2018 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 2566 газрын дуудлага худалдаа, 366 газрын эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 13962 өмчлөх, эзэмших эрхийн барьцаа, 16056 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэж оруулсан бөгөөд тухайн жилд 8.5 тэр бум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Тус системийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, 330 сумын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус систем нь Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц, Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан, Газрын үнэлгээний мэдээллийн сантай болон холбогдох бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдон ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Мөн Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнө иргэн, хуулийн этгээд газрын эрхийн дуудлага худалдаанд оролцохын тулд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй Газрын алба, банк зэрэг байгууллагуудад заавал биеэр очиж үйлчлүүлэх шаардлагатай байсан бол тус систем нэвтэрснээр интернетэд холбогдсон компьютер, гар утас, таблет зэрэг төхөөрөмжүүдийг ашиглан хаанаас ч оролцох олон шат дамжлагагүй, түргэн шуурхай үйлчилгээг авах боломжтой болсон.

---oOo---

4. ГАЗРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор “Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваарь”, “Хот тосгон, бусад суурины газрын зэрэглэл, тэдгээрийн нэг га-ийн суурь үнэлгээ”, “Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог бүрийн 1 га-ийн суурь үнэлгээ”-г тус тус баталж өнөөг хүртэл 21 жил дагаж мөрдөж байсан.

Энэхүү тогтоолыг Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний бүс /тойрог, зэрэглэл/, суурь үнэлгээ, төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 182 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан.

Мөн Газрын суурь үнэлгээ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор газрын үнэлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, түргэн шуурхай болгох зорилгоор Газрын кадастрын мэдээллийн санд суурилсан Газрын үнэлгээний системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлээ.

Газрын үнэлгээний систем нь нэгдмэл сангийн 6 ангилал тус бүрийн газрын суурь үнэлгээг үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс болон газрын зах зээлийн бодит үнийг ашиглан автоматаар тооцоолох боломжтой юм. Тухайлбал: Хот суурин газрын үнэлгээг байгаль орчин, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн гэсэн 18 төрлийн хүчин зүйлсийг харгалзан тооцоолж байна.

Газрын үнэлгээний системийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

- Олон улсад ашиглагддаг масс үнэлгээний арга зүйг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж Газрын үнэлгээний нэгдсэн арга зүй, аргачлалтай болсон;
- Газрын үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийн 39 давхарга мэдээллийн сан бий болсон;
- Газрын зах зээлийн үнийн найдвартай, үнэн бодитой мэдээллийн сантай болж, газрын зах зээлийн үнэ цэнэ болон газрын суурь үнэлгээг иргэд олон нийтэд нээлттэй ил тод болгосон;
- Газрын нэгдмэл сангийн 6 ангилал тус бүрээр үнэлгээ хийж, газрын суурь үнэлгээг тогтмол шинэчлэх боломж бүрдсэн. Өөрөөр хэвлэл Монгол улсын бүх газар нутаг үнэ цэнэтэй болох юм.

---oOo---

5. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Улсын хэмжээнд Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын Газрын бүртгэл, зураглалыг засварлаж, нэгдсэн стандартад оруулж, цаасан хувийн хэргийг материалыг тоон хэлбэрт шилжүүлж, байрлалд суурилсан Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг нэвтрүүлэв.

Энэхүү системийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр газрын бүртгэл, зураглалын алдааг бүрэн засварлаж, цаасан хувийн хэргийн материалыг цэгцлэх, цахимжуулах ажлыг хийж, нэгдсэн санд бүртгэж баталгаажуулсан бөгөөд албан хаагчдын хийж буй газрын бүртгэл нээлттэй, шат бүрд хяналттай болж, шийдвэр гаргагч нарыг бодит агшны мэдээллээр хангах боломжтой болсон.

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем хангамжийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

1. Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн нэгдсэн нэг стандарттай мэдээлэл бүхий систем байгуулагдаж, Монгол Улсын хэмжээнд нэгдсэн сүлжээнд холбогдож, аймаг, сумын Газрын кадастрын мэдээллийн санд орч буй өөрчлөлт, шинэчлэлтийн ажил ГЗБГЗЗГ-т байрлаж буй нэгдсэн системд орж, нөөцлөгдөх боломжтой болсон.
2. Газрын кадастрын мэдээллийн сангийн програм хангамж нь нийт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой 40 гаруй төрлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, 61 гаруй төрлийн тайлан мэдээ гарах, 15 гаруй төрлийн хяналт шалгалтыг автоматаар хийх болон Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголт хийх, өргөдлийг хүлээн авсан хугацааны дагуу шийдвэрлэх гэх мэт олон боломжийг бүрдүүлсэн Газрын кадастрын мэдээллийн сангийн цогц систем юм.
3. Газрын кадастрын мэдээллээр үйлчлэх боломж бүхий нэгдсэн мэдээллийн сангийн програм хангамжтай болж иргэд интернет ашиглан газрын харилцаатай холбоотой мэдээллийг авах, өргөдөл шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээлэл болон өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын талаарх мэдээллийг тус тус харах, хянах боломжийг бүрдүүлсэн.
4. Кадастрын нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд бүх албан хаагчдын ашиглаж буй тоног төхөөрөмжийг шинэчлэх, өгөгдлийн санг байгуулах, сервер, хадгалах төхөөрөмжийн нийлүүлэлтийг хийсэн бөгөөд газрын салбарт хийгдсэн томоохон технологийн дэвшлийг бүрдүүлсэн юм.
5. Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг бусад байгууллагуудтай холбож, бүхий л сервес үйлчилгээг гаргасан бөгөөд одоогийн байдлаар Байгаль, орчин, аялал, жуулчлал яам, Чөлөөт бүсийн газар тус тус ашиглан нэгдсэн бүртгэлд шилжээд байна.

Мөн Газрын кадастрын мэдээллийн санг ДАН системтэй холбох ажил хийгдэж, иргэн, аж ахуйн нэгжүүд орон зай цаг хугацаанаас үл хамааран өөрийн газартай холбоотой буюу кадастрын зураг, гэрээ, гэрчилгээ, захирамж гэх мэдээллүүдийг цахимаар авах боломжтой болсон.

---oOo---

5.1. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ ХОЛБОЖ ДУНДЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЙГУУЛАВ

Улсын хэмжээнд ашиглаж буй газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Үндэсний дата төвд байрлуулж, ХУР системээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэв.

Дундын мэдээллийн санг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

1. Иргэн аж ахуй нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийг Улсын бүртгэлийн газар хянан үзээд Э болон А дугаарыг цахимаар илгээж тухайн дугаарыг гэрчилгээнд тавьж баталгаажуулдаг болсон.
2. Хоёр байгууллагын мэдээллийн сан нэгдэж, байрлалд суурилсан давхцалгүй бүртгэлийг хийх боломжтой болсон.
3. Газрын бүртгэл, баталгаажилтыг хийлгэхийн тулд иргэд, аж ахуй нэгжүүд хоёр байгууллагын дунд явж, цаг хугацаа их алддаг байсан бол нэг цэгээс буюу газрын албанаас бүхий л үйлчилгээг авах боломжтой болсон.

2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт хүлээгдэж буй 734 өргөдөл, 63602 нэгж талбарт Э болон А дугаар олгосон бөгөөд 14026 нэгж талбарт татгалзсан хариуг ирүүлээд байна.

---oOo---

5.2. ГАЗРЫН ТАТВАР, ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЖ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ ДУНДЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЙГУУЛАВ

Газрын төлбөр, татвар ногдуулалтыг цахим хэлбэрээр харж, банкны аппликэйшн /интернет банк, мобайл банк, АТМ гэх мэт/ ашиглан хаанаас ч, хялбар аргаар төлөх боломжтой Газрын төлбөр, татварын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүллээ.

Газрын төлбөр, татварын системээр газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг орон нутгийн газрын асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан автоматаар тооцож ногдуулах боломжтой бөгөөд газрын төлбөр, татвар, хураамж төлөгч дурын банкны аппликэйшн /интернет банк, мобайл банк, АТМ гэх мэт/ ашиглан хялбар төлөх боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн газрын төлбөр, татвар тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг ногдуулах, хураах ажилд тухай бүр хяналт тавих боломжоор хангагдлаа.

Газрын төлбөр, татварын системийг Улсын хэмжээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

4. Засгийн газрын тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээ, сум, дүүргийн ИТХ-аар батлагдсан газрын төлбөр, татвар ногдуулах хувь хэмжээ, газрын төлбөрийн тухай хууль, үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд заасан газрын төлбөр, татвараас хөнгөлөх, чөлөөлөх, нэмэгдүүлэх хувь, хэмжээ тус бүрийг системд оруулсан;
5. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн нэгж талбар бүрт газрын төлбөр, татварыг тэгш шударга ногдуулах, газрын төлбөр төлөгчид газрын төлбөрөө дурын банкны аппликэйшн /Интернет банк, мобайл банк, АТМ гэх мэт/ ашиглан хаанаас ч төлөх боломж бүрдсэн;
6. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Татварын ерөнхий газрыг холбосон дундын мэдээллийн сан бий болж, газрын төлбөр, татварын харилцаа хяналттай болсон;
7. Газрын төлбөр, татвараас орох улсын төсвийн орлого нэмэгдэнэ.

---oOo---

5.3. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ БАЙГАЛЬ, ОРЧИН, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР БОЛОН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАЗАРТ НЭВТРҮҮЛЭВ

Улсын хэмжээнд ашиглаж буй газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Байгаль, орчин, аялал, жуулчлал яамны тусгай хамгаалалтай газар болон Чөлөөт бүсийн газарт нэвтрүүлэв.

Дээрх системийг нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

1. Гурван байгууллагын мэдээллийн сан нэгдэж, нэгдсэн стандартад шилжив.
2. Газрын зөрчил маргааныг илрүүлэн хоёр талаас шийдвэрлэх боломжтой болсон ба цаашид газрын зөрчил маргаан гаргах боломжгүй болоод байна.
3. Тусгай хамгаалалтай газарт газар олгох үйл ажиллагааны процессыг Дундын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулах боломжтой болсон.
4. Цахимаар хоёр байгууллагууд тухай бүр мэдээллээ солилцох бүрэн боломжтой болсон.

2020 оны байдлаар Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх олгогдсон нийт 3260 нэгж талбарууд бүртгэгдээд байна.

---oOo---

5.4. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ХУР СИСТЕМД ХОЛБОЖ ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЭВ

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн нөөц хувилбарыг Үндэсний дата төвд байрлуулан ХУР системд холбож, хэрэглээнд нэвтрүүлэв.

ХУР системд холбогдсоноор дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

1. Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох бүрэн боломжтой болсон бөгөөд газартай холбоотой сервис үйлчилгээнүүдийг Дата төвд нэгдсэн стандартын дагуу гаргаж, шууд холбогдох боломжтой болсон
2. Хурууны хээ нь төхөөрөмжөөр дамжуулан иргэний бүртгэлийг Газрын кадастрын мэдээллийн санд шууд автоматаар бүртгэх боломжтой болсон бөгөөд иргэдийн мэдээлэл давхцалгүй болсон билээ.

---oOo---

5.5. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ДАН СИСТЕМД ХОЛБОЖ ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЭВ

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн нөөц хувилбарыг Үндэсний дата төвд байрлуулан ДАН системд холбож, хэрэглээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

3. Иргэн, аж ахуйн нэгжүүд орон зай цаг хугацаанаас үл хамааран өөрийн газартай холбоотой буюу кадастрын зураг, гэрээ, гэрчилгээ, захирамж гэх мэдээллүүдийг QR кодоор баталгаажуулан цахимаар авах боломжтой болсон.
4. Газрын кадастрын мэдээллийн сангийн хэрэглээнд Тоон гарын үсгийг нэвтрүүлэв.

---oOo---

5.6. ГАЗРЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ИРГЭД ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ВЕБ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭВ WWW.EGAZAR.GOV.MN

Олон нийтэд зориулсан Газрын кадастрын мэдээллийн сангийн веб системээс иргэн, аж ахуйн нэгж цаг хугацаа, орон зайнаас үл хамааран газартай холбоотой бүхий үйлчилгээг цаг хуагцаа, орон зайнаас үл хамааран авах боломжтой болсон.Үүнд:

1. Өргөдлийн хяналт. Иргэн газартай холбоотой гаргасан өргөдлөө хэн гэдэг мэргэжилтэнд, ямар шатандаа шийдвэрлэгдэж байгааг харах боломжтой.
2. Эрхийн баталгаажуулалт. Өөрийн газрын мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг харах боломжтой.
3. Нэгж талбарын мэдээлэл. Нэгж талбартай холбоотой талбайн хэмжээ, хаяг, байршил зэрэг мэдээллийг харах боломжтой.
4. Тухай шатны Засаг даргын шийдвэр, шийдвэрийн дугаар, огноо, гэрээ, гэрчилгээ, түүний дугаарыг тус тус харах боломжтой болсон.
5. Төлбөр, татварын мэдээлэл. Газрын төлбөр, татвар хэдэн төгрөг төлөх болон, төлбөрийн үлдэгдэл, данстай холбоотой мэдээлэл харах боломжтой.
6. Газрын үнэлгээ, суурь үнэлгээ. Өөрийн өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газрын суурь үнэлгээ болон дуудлага худалдааны анхны үнэ, үнэлгээний бүсчлэлтэй холбоотой мэдээлэл харах боломжтой.
7. Тухайн газрын гадаргын өндөршил, гадаргын налуу, сургууль хүртэлх зай, цэцэрлэг хүртэлх зай, эмнэлэг болон тамгын газар хүртэлх зай гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй харах боломжтой.
8. Иргэн, аж ахуй нэгжүүд газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөнд саналаа өгөх боломжтой.

Дээрх веб системээс гар утас, интернет ашиглан газартай холбоотой бүхий мэдээллийг нээлттэй харах боломжтой болоод байна.

---oOo---

ГЕОПОРТАЛ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЭЦ

Орон зайн мэдээллийг бусад холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, түгээх болон эдгээрийн шинэлэг, баталгаатай, чанартай, бэлэн байдлыг хангах, Үндэсний орон зайн зайн өгөгдлийн дэд бүтцийг бэхжүүлэх, мэдээлэл бүрдүүлэгч, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

Орон зайн мэдээлэл нь нийгэм, эдийн засгийн үнэ цэнийг агуулсан үндэсний мэдээллийн чухал нөөц ба хүн төрөлхтөн, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны үйл ажиллагаа өрнөж буй физик дэлхийн шинж чанарыг илэрхийлэхийн зэрэгцээ, манай дэлхийн дижитал хувилбарыг дүрсэлдэг. Энэхүү дижитал дэлхийн хувилбаргүйгээр дижитал эдийн засгийг төсөөлөхийн аргагүй юм.

Байрлалд суурилсан орон зайн мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргалт, бодлого тодорхойлолтыг дэмжих, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад орон зайн мэдээллийн бэлэн, шинэлэг, баталгаатай байдлыг хангах үүднээс 16 суурь орон зайн мэдээллийг тодорхойлоод байна. Үүнд: Геодезийн тулгуур сүлжээ, Байр зүйн зураг, Хил зааг, Хаяг, Барилга, суурин газар, Өндөржилт, гүн, Газар зүйн нэр, Газрын бүрхэвч, газар ашиглалт, Газрын нэгж талбар, Дэд бүтэц, Тээврийн сүлжээ, Ус зүйн мэдээлэл, Ортозураг, Хөрс, геологи, Түүх, соёл, археологийн өв, Хүн ам зүйн мэдээлэл орно. Уг жагсаалт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн Орон Зайн Мэдээллийн Менежментийн Зөвлөхүүдийн Хорооноос гаргасан удирдамж чиглэлтэй нийцэж байгаа болно.

Дээрх суурь 16 давхаргыг агуулсан Геопорталыг тус газар нь 2019 оны 12 дугаар сараас эхлэн албан ёсоор хэрэглээнд гаргаж олон нийтэд цахим хаяг / **Geoportal.nsd.gov.mn** /-аар нээлттэй түгээж байна.

Геопортал нь газар зүйн мэдээллийн системийн үйлчилгээнүүд, веб аппликэйшнүүд, орон зайн суурь мэдээллүүдийг нэгдсэн байдлаар бүртгэн зохион байгуулж тэдгээрийг вебээр дамжуулан хэрэглэгчдэд хялбар хайх, хандах, хэрэглэх боломжтой систем юм.

2019 онд ГЗБГЗЗГ-ын геопорталаар нийт 8 ангиллын 26 дэд төрлийн орон зайн мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад орон зайн веб үйлчилгээгээр гаргасан. 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 18 төрийн байгууллагад суурь орон зайн мэдээллээр үйлчилж хамтран ажиллаж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг боловсронгуй болгож, байрлалд суурилсан орон зайн мэдээллийг цахимаар хайх, хандах, хэрэглэх боломж бүхий Үндэсний Геопортал хөгжүүлэх, Манай улсын байгаль, нийгэм, эдийн засгийн бүх салбарт **НЭГ УЛС-НЭГ ГАЗРЫН ЗУРАГ** төсөл хэрэгжүүлэх замаар газрыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн зураглах, бүртгэх, бүх төрлийн төлөвлөлтүүдийг хооронд нь уялдуулах, бодит мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, бодлого тодорхойлолтыг дэмжих, салбар бүрд орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээхүйц бизнесийн санаа, инновац бүтээх орчныг хөшүүрэгдэх, Ухаалаг цахим засаглалыг дэмжих зорилго тавин ажиллаж байна.

Орон зайн цахим системүүдээс:

a. geoportal - байрлалд суурилсан орон зайн мэдээллээр төрийн байгууллага, хэрэглэгчдийг хангах цахим платформ. 16 төрлийн 70 гаруй сэдэвт мэдээлэл өнөөдрийн байдлаар агуулж байна /тухайлбал, байрзүйн зураг, хаягийн мэдээлэл, газарзүйн нэр, барилга, нэгж талбар, хөрс ургамал, газар ашиглалт, зам тээвэр гэх мэт/. geoportal.nsd.gov.mn;

b. МОНТОР1К - 21 аймгийн 1:1000 байр зүй болон газар дээрх доорх инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан;

c. UrbanManager - барилга, байгууламж, газар дээрх, доорх инженерийн дэд бүтцийн төрөлжсөн бүртгэлийн мэдээллийн сан.

---oOo---